



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар A/400

Булган сум

Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг  
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/376 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үүднээс Булган сумын нутаг дэвсгэрт явуулахаар төлөвлөсөн газарт газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: С.Наранбаатар (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Дуудлага худалдааны хөтлөгч: Б.Отгонжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын төлбөр, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Н.Отгонжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг явуулахыг ажлын хэсэг (С.Наранбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

